



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

2021

Э-сонин

04-Р САР

93-р дугаар






Зах зээлийн тойм


/2021.04.30-ны өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр	22
2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/	533,685,141,221.93
Хувьцаа /хоёрдогч/	34,005,744,144.77
Багцын арилжаа	3,738,131,153
Хөрөнгө оруулалтын сан /хоёрдогч/	1,881,396,077.15
Компанийн бонд /анхдагч/	347,736,470,000
Компанийн бонд /хоёрдогч/	150,061,531,000
ХБҮЦ /хоёрдогч/	
3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг	66,606,460
Хувьцаа /хоёрдогч/	57,877,854
Багцын арилжаа	10,226,639
Хөрөнгө орцлалтын сан /хоёрдогч/	4,472,352
Компанийн бонд /анхдагч/	2,755,639
Компанийн бонд /хоёрдогч/	1,500,615
ХБҮЦ /хоёрдогч/	0
4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо	34,873

TOP-20 индекс




MSE B индекс



Зах зээлийн үнэлгээ



MSE A индекс



БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААС

1. Нийт үнэт цаас	185
100% төрийн өмчит	17
Төрийн өмчийн оролцоотой	10
Хувийн өмчийн	158
I ангилал	18
II ангилал	42
III ангилал	125
Компанийн бонд	2
Хөрөнгө оруулалтын сан	1
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	1

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо	53
Үүнээс: Брокер, Дилер	53
Андеррайтер	16
Хөрөнгө оруулалтын зөвлөх	14



АРИЛЖААНД ИДЭВХТЭЙ ОРОЛЦСОН ГИШҮҮН ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИУД

/2021.04.30-ны байдлаар/

	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн / авсан, зарсан/ (төг)
		Тоо ширхэг	Үнийн дүн (төг)	Тоо ширхэг	Үнийн дүн (төг)	
1	БИДИСЕК ХК	2,686,693	104,277,865,750	5,447,910	348,466,040,871	452,743,906,620.96
2	ТИ ДИ БИ КАПИТАЛ ХХК	4,716,472	106,203,611,966	4,172,686	85,815,962,903	192,019,574,868.85
3	ГОЛОМТ КАПИТАЛ ХХК	3,159,183	94,659,872,786	5,505,005	65,789,597,625	160,449,470,411.67
4	БУЛГАН БРОКЕР ХХК	1,516,486	150,037,782,471	22,104	1,026,343	150,038,808,813.70
5	АРД СЕКЮРИТИЗ ХХК	32,390,132	28,249,508,736	27,516,654	26,303,824,285	54,553,333,021.48
6	ТЭНГЭР КАПИТАЛ ХХК	185,942	20,689,523,919	31,897	12,417,605	20,701,941,524.12
7	НОВЕЛ ИНВЕСТМЕНТ ХХК	576,736	7,749,970,678	418,555	195,993,482	7,945,964,160.87
8	ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК	1,296,320	3,566,502,065	1,300,887	3,539,368,330	7,105,870,394.50
9	ЛАЙФТАЙМ ИНВЕСТМЕНТ ХХК	31,684	5,732,782,840	3,597	1,520,656	5,734,303,495.70
10	БУМБАТ-АЛТАЙ ХХК	2,225,478	2,997,818,163	2,242,563	628,431,935	3,626,250,097.93
11	СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ХХК	10,021,428	1,285,142,050	11,534,758	979,468,746	2,264,610,796.24
12	АПЕКС КАПИТАЛ ҮЦК	2,404,784	1,890,488,760	1,701,310	323,977,080	2,214,465,840.13
13	ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК	1,882,505	862,395,291	3,124,806	632,569,927	1,494,965,217.74
14	МИРЭ ЭССЕТ СЕКЮРИТИС МОНГОЛ ХХК	247,113	987,036,962	1,277,105	106,713,456	1,093,750,418.02
15	ЗЭРГЭД ХХК	39,782	786,020,444	73,683	13,643,018	799,663,462.11
16	ЭМ АЙ СИ СИ ХХК	6,089	597,554,750	10,952	1,433,401	598,988,151.00
17	ГҮҮДСЕК ХХК	543,123	354,487,901	737,265	229,928,395	584,416,295.18
18	ДАРХАН БРОКЕР ХХК	49,851	295,660,628	67,499	131,042,020	426,702,647.49
19	АРГАЙ БЭСТ ХХК	83,215	418,467,354	10,550	6,071,034	424,538,387.95
20	АЛТАН ХОРОМСОГ ХХК	1,465	416,045,000	0	0	416,045,000.00

ИДЭВХТЭЙ АРИЛЖИГДСАН ХУВЬЦАА

/2021.04.30-ны байдлаар/

№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн (төг)	Дээд Ханш	Доод Ханш	Өөрчлөлт /%/
1	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	1,651,359	17,478,587,750.00	13,000.00	9,600.00	9.53
2	ADB	АРД КРЕДИТ ББСБ ХК	21,436,451	6,525,835,948.48	360.00	220.00	19.67
3	INV	ИНВЕСКОР ББСБ	1,337,488	3,662,924,262.00	3,500.00	2,850.00	6.31
4	AIC	АРД ДААТГАЛ ХК	1,709,837	2,834,964,080.00	1,800.00	1,300.00	1.92
5	XOC	ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН	4,472,352	1,881,396,077.15	750.00	255.00	11.73
6	APU	АПУ	1,082,753	777,359,941.72	730.00	691.00	-2.66
7	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	7,731,441	561,396,615.03	75.50	63.50	10.89
8	GOV	ГОВЬ	1,980,756	471,031,447.12	247.80	233.00	0.62
9	LEND	ЛЭНДМН ББСБ ХК	4,448,918	211,060,961.31	52.89	40.01	11.41
10	MRX	МЕРЕКС	9,101,862	201,971,645.25	34.00	25.00	18.52
11	TUM	ТҮМЭН ШУВУУТ	853,084	181,618,505.17	217.90	209.00	0.50
12	MNP	МОНГОЛ ШУУДАН ХК	94,038	149,528,081.00	1,784.00	1,270.00	-11.28
13	TTL	ТАВАН ТОЛГОЙ	14,568	103,325,310.00	7,500.00	6,690.00	-7.83
14	HVL	ХӨВСГӨЛ	48,690	100,009,260.00	2,054.00	2,054.00	0.00
15	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	48,224	89,172,321.00	2,100.00	1,600.00	15.81
16	MFC	МОНОС ХҮНС	1,275,776	86,584,845.24	72.00	65.01	-5.96
17	ERDN	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН ХК	86,137	78,775,810.33	950.00	850.00	-3.14
18	SUU	СҮҮ	364,189	76,985,586.27	217.00	206.00	-2.50
19	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,228,484	62,885,844.31	31.00	26.50	-6.86
20	MBW	МОНГОЛ БАЗАЛЫТ ХК	273,156	47,332,211.85	181.00	165.00	-5.35



ХАНШИЙН ӨСӨЛТТЭЙ ХУВЬЦАА

/2021.04.30-ны байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан / Ширхэг/	Хаалтын ханш (төг)		Ханшийн өөрчлөлт (төг)	Өөрчлөлт /%/
			2021-04-01	2021-04-30		
1	ГАН ХИЙЦ	19	11,840.00	15,700.00	3,860.00	32.60
2	БУЛГАН УНДРАГА	5,907	6,165.00	8,145.00	1,980.00	32.12
3	МОННООС	41	1,900.00	2,500.00	600.00	31.58
4	МОНГОЛ ДААТГАЛ	289	1,820.00	2,350.00	530.00	29.12
5	МОГОЙН ГОЛ	661	8,600.00	10,500.00	1,900.00	22.09
6	МОНГОЛ ШЕВРО	19	1,230.00	1,480.00	250.00	20.33
7	АРД КРЕДИТ ББСБ ХК	21,436,451	250.23	299.44	49.21	19.67
8	МЕРЕКС	9,101,862	24.89	29.50	4.61	18.52
9	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	48,224	1,727.00	2,000.00	273.00	15.81
10	МОН-ИТ БУЛИГААР	2	5,100.00	5,865.00	765.00	15.00
11	ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ	1,805	114.07	131.15	17.08	14.97
12	ГУТАЛ	36	22,600.00	25,980.00	3,380.00	14.96
13	ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН	4,472,352	259.70	290.15	30.45	11.73
14	СТАНДАРТ АГРИКАЛЧЕР ГРУПП	25	112.00	125.00	13.00	11.61
15	ЛЭНДМН ББСБ ХК	4,448,918	44.80	49.91	5.11	11.41
16	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	331	78,100.00	86,960.00	8,860.00	11.34
17	МАНДАЛ ДААТГАЛ	7,731,441	66.85	74.13	7.28	10.89
18	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	1,651,359	10,180.00	11,150.00	970.00	9.53
19	ШИВЭЭ ОВОО	495	1,630.00	1,785.00	155.00	9.51
20	ТАЛХ ЧИХЭР	1,698	14,200.00	15,290.00	1,090.00	7.68

ХАНШИЙН БУУРАЛТТАЙ ХУВЬЦАА

/2021.04.30-ны байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан /Ширхэг/	Хаалтын ханш (төг)		Ханшийн өөрчлөлт (төг)	Өөрчлөлт %
			2021-04-01	2021-04-30		
1	МОНГОЛ АЛТ	1,774	26,000.00	16,500.00	-9,500.00	-36.54
2	ТАВ	181	13,750.00	9,000.00	-4,750.00	-34.55
3	СИЛК НЕТ	48	1,065.00	775.00	-290.00	-27.23
4	РЕМИКОН	833,544	33.15	28.50	-4.65	-14.03
5	ДАРХАН ХӨВӨН	151	8,000.00	6,900.00	-1,100.00	-13.75
6	БЭРХ УУЛ	388	2,428.00	2,106.00	-322.00	-13.26
7	СОР	5,205	513.53	450.00	-63.53	-12.37
8	Э-ТРАНС ЛОЖИСТИКС	142,680	113.99	101.00	-12.99	-11.40
9	МОНГОЛ ШУУДАН ХК	94,038	1,694.00	1,503.00	-191.00	-11.28
10	ХӨХ ГАН	33,938	89.00	79.93	-9.07	-10.19
11	АДУУН ЧУЛУУН	3,566	993.31	894.67	-98.64	-9.93
12	ТЕХНИК ИМПОРТ	54	10,230.00	9,250.00	-980.00	-9.58
13	СОНСГОЛОН БАРМАТ	4	2,000.00	1,810.00	-190.00	-9.50
14	ТАХЬ-КО	1	12,000.00	11,000.00	-1,000.00	-8.33
15	ТАВАН ТОЛГОЙ	14,568	7,410.00	6,830.00	-580.00	-7.83



"ЭТТ БОНД" МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖЭЭР АМЖИЛТТАЙ АРИЛЖИГДЛАА

Монголын хөрөнгийн бирж нь "Эрдэнэс тавантолгой" ХК-ийн орлогоор баталгаажсан 100,000 төгрөг болон 100 ам.долларын нэрлэсэн үнэтэй, хоёр жилийн хугацаатай "ЭТТ Бонд"-ын анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2021 оны 3 дугаар сарын 30-наас 2021 оны 4 дүгээр сарын 09-ний өдрүүдэд гишүүн үнэт цаасны компаниудаараа дамжуулан хүлээн авч, анхдагч зах зээлийн арилжааг амжилттай зохион байгууллаа.

Үнэт цаасны арилжаанд нийт 973 иргэн, аж ахуйн нэгж оролцож, 2,755,639 ширхэг захиалга ирүүлснээр 347.7 тэрбум төгрөг, банкуудын дахин санхүүжилтийн гэрээний дагуу 330 тэрбум төгрөг буюу нийт 677.7 тэрбум төгрөгийн багцын санхүүжилтийг бүрдүүлсэн байна.

СЗХ-ны даргын 2021 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 1/1387 тоот албан бичгээр "Эрдэнэс тавантолгой" ХК-ийн нийтэд санал болгон арилжаалсан "ЭТТ Бонд"-ын анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцсон бөгөөд бондын арилжааг 2021 оны 4 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлүүлэх зөвшөөрлийг олгосон байна. Иймээс хөрөнгө оруулагчид анхдагч зах зээлийн арилжаанаас үлдсэн мөнгийг үнэт цаасны компаниараа дамжуулан будаан авах эрх үүслээ.

Харин бондын хоёрдогч зах зээлийн арилжааг "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК дахь хөрөнгө оруулагчдын дансанд бондыг байршуулан холбогдох мэдээллийг солилцсоны дараа буюу 2021 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр эхлүүлэв.



ҮЙЛ ЯВДАЛ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД БҮРТГЭЛТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН АНХААРАЛД

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниуд нь Санхүүгийн зохицуулах хорооны "Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журам"-ын 2.2 дох заалтын дагуу компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлангаа 4 дүгээр сарын 01-ний өдөрт багтаан МХБ-д ирүүлэхээр заасан байдаг.

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниуд нь Санхүүгийн зохицуулах хорооны "Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журам"-ын 2.2 дох заалтын дагуу компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлангаа 4 дүгээр сарын 01-ний өдөрт багтаан МХБ-д ирүүлэхээр заасан байдаг.

Монголын хөрөнгийн биржийн зүгээс тайлан ирүүлээгүй компаниудад 4 дүгээр сарын 12-ны дотор ирүүлэх хугацаа олгож байна. Иймээс хувьцаат компанийн олон нийтэд нээлттэй, ил тод байх компанийн засаглалын сайн жишгийг хангаж, үйл ажиллагааны тайлангаа заасан хугацаанд багтаан ирүүлнэ үү.

Хэрэв заасан хугацаанд хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Монголын хөрөнгийн биржийн зүгээс тус зөрчлийн талаар олон нийтэд болон Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэж, СЗХ-ны "Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журам", МХБ-ийн холбогдох журмууд болон Бүртгэлийн гэрээнд заасан хариуцлагын арга хэмжээг ногдуулахыг анхаарна уу.

"ЗООС БАНК" ХК-ИЙГ ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛЭЭС ХАСЛАА

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Санхүүгийн зохицуулах хорооны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.1, 3.2.10 дахь заалтууд, Монгол Банкны Ерөнхийлөгчийн 2009 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн №650 тоот тушаал, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.10.11, "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 23 дугаар зүйлийн 23.11.1 дэх заалт болон СЗХ-ны 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн № 9/1227 тоот албан бичгийг тус тус үндэслэн "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/31 тоот тушаалаар "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн 3-р ангилалд бүртгэлтэй "Зоос банк" ХК-ийг бүртгэлтэй хувьцаат компанийг бүртгэлээс хаслаа.



"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК-ИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРИЛГА

"Эрдэнэс Тавантолгой ХК" нь андеррайтер, брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн түншилсэн (Синдикат) зөвлөх үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьсан байна.

Энэхүү зөвлөх үйлчилгээ нь **Тавантолгойн нүүрсний орд газрыг түшиглэн үндэсний хэмжээний томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоолоор дотоодын үнэт цаасны зах зээлд нийтэд санал болгон 2,000,000,000,000 /хоёр их наяд/ төгрөг хүртэлх хэмжээний ЭТТ-Бонд гаргахаар шийдвэрлэсний хүрээнд 1,400,000,000,000 /Нэг их наяд дөрвөн зуун тэрбум/ төгрөг болон дүйцэх ам.долларын хэмжээтэй санхүүжилт татан төвлөрүүлэхтэй холбогдсон харилцаанд андеррайтерийн үйлчилгээг үзүүлэх** болно.

Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх этгээд нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээллийг (нийтлэл, ижил төрлийн ажлын туршлага, ажиллах боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл гэх мэт) ирүүлнэ. Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг **2021 оны 04 дүгээр сарын 23-аас 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 07:30-16:30** хооронд amgalanbayar.j@erdenestt.mn цахим хаягаар хүсэлтээ ирүүлэн авч болох бөгөөд мэдүүлгээ дор дурдсан хаягаар **2021 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 11:00 цагийн** дотор хүргүүлнэ үү.

"Эрдэнэс Тавантолгой" ХК, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Жигжиджав-8, Финанс төв, 5 давхар 503 тоот,

Утас: 75055555 дотуур утас-509

Гар утас: 94187299

"ЛЭНДМН ББСБ" ХК НИЙТ ГАРГАСАН ХУВЬЦААНЫ 5 ХҮРТЭЛХ ХУВИЙГ ДАХИН ХАЛААСЛАХААР ШИЙДВЭРЛЭСЭН БАЙНА

"ЛэндМН ББСБ" ХК нь Компанийн тухай хуулийн 49, 55, 76 дугаар зүйлд нийцүүлэн гаргасан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 20/37 тоот тогтоолын дагуу 2020 оны 12 сарын 24-ний өдрөөс эхлэн Монголын хөрөнгийн биржээс өөрийн хувьцааг эргүүлэн худалдан авах боломжтой болсон бөгөөд 2020 оны 12-р сарын 24-ний өдрөөс 2021 оны 03-р сарын 31-ний өдрийн хооронд **37,609,730** ширхэг хувьцааг худалдан авч халаасалсан байна.

"ЛэндМН ББСБ" ХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн ээлжит хурал 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулагдаж, тус хурлаар компанийн гаргасан хувьцааны эргэлтийг сайжруулах, хувьцааны ханшийг тогтворжуулах зорилгоор өөрийн гаргасан хувьцааг эргүүлэн худалдан авах шийдвэрийг дахин гаргаж, ТУЗ-ийн 21/17 тогтоолоор баталлаа.

ҮЙЛ ЯВДАЛ

Уг тогтоолоор компанийн нийт гаргасан хувьцааны 5 /тав/ хувиас хэтрэхгүй хэмжээний хувьцааг олон нийтээс эргүүлэн худалдан авч халааслах нөхцөлийг баталсан бөгөөд уг нөхцөлд хувьцааг эргүүлэн авах захиалгын дээд үнийг тогтоохдоо өмнөх 30 хоногийн Хөрөнгийн биржийн арилжаа хийсэн өдрүүдийн жигнэсэн дундаж ханшийг 5 хувиар нэмэгдүүлснээс хэтрэхгүй ханшаар олон нийтээс худалдан авна гэж заасан байна.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРЕЙШН ХАР МОРЬ ТАЛБАЙН ХАЙГУУЛЫН ҮР ДҮНГ ТАНИЛЦУУЛСАН БАЙНА

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD | MSE:ERDN) ("Эрдэнэ Ресурс" эсвэл "Компани") нь Хар Морь талбайн Дэл бүсийн өмнөд хэсэгт хийсэн өрөмдлөгийн хайгуулын хөтөлбөрийн анхан шатны үр дүнг танилцуулсан байна.

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: "Томоохон эрдэсжилтийг илрүүлсэн өнөөг хүртэлх хайгуулын хөтөлбөрүүдийн үр дүнг баталгаажуулан, AAD-81 цоонгт газрын дөт гүнээс эхлэн 2.67 г/т алтны агуулга бүхий 35 метрийн интервалыг огтолсон нь Улаан - Хөндий хувирлын системийн хэтийн төлөвийг харуулж байна. AAD-81 цооногийн интервал нь шинээр нээн илрүүлсэн системийн цар хүрээ болон Хар Морь талбайн Дэл бүсийг өмнө зүгт тэлэх боломжийг харуулж байна" хэмээн онцоллоо.

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

№	Компанийн нэр	Цаг	Өдөр	Тайлбар
1	"Хорин хоёрдугаар бааз ХК		2021.04.29	Ээлжит хурал
2	"Хот Девелопмент" ХК	10:00	2021.04.29	Ээлжит хурал
3	"Шарын гол" ХК	13:00	2021.04.27	Ээлжит хурал
4	"Хай Би Ойл" ХК	10:00	2021.04.26	Ээлжит хурал
5	"Дархан гурил тэжээл" ХК	12:00	2021.04.24	Ээлжит хурал
6	"Гермес Центр" ХК	15:00	2021.04.09	Ээлжит хурал



"СТАНДАРТ АГРИКАЛЧЕР ГРУПП" ХК-ИЙН ХУВЬЦААГ ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР САНАЛ ЗАРЛАГДЛАА

"Эм Ди Кэй Ай" ХХК нь 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдөр "Стандарт агрикалчер групп" ХК-ийн 13,607,865 ширхэг буюу нийт гаргасан хувьцааны 99.07 хувийн хяналтын багцыг дангаараа Монголын хөрөнгийн биржийн багцын арилжаагаар худалдан авсан болно.

Иймээс компанийн тухай хуулийн 57.1 дэх заалтын дагуу үүргээ хэрэгжүүлэх үндсэн дээр бусад хувьцаа эзэмшигчдэд хувьцаа худалдан авах дараах саналыг гаргаж байна. Үүнд:

1. Худалдан авах санал гаргаж буй хуулийн этгээдийн мэдээлэл:

- a. Хуулийн этгээдийн нэр: "Эм Ди Кэй Ай" ХХК
- b. Хаяг: Баянгол дүүрэг, 16-р хороо, Шинэ Монгол хаад группын байр, 2 давхар
- c. Холбоо барих утас: 91993560, 91110444
- d. Улсын бүртгэлийн дугаар: 9019037048
- e. Регистрийн дугаар: 5208211

2. Худалдан авахаар зарласан нийт хувьцааны тоо ширхэг: 95,190 ширхэг

3. Худалдан авах саналын эхлэх, дуусах огноо: 2021.04.19 - 2021.05.19

4. Худалдах саналыг хүлээн авах өдөр: 2021.05.19

5. "Эм Ди Кэй Ай" ХХК-ийн эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг: 13,607,865 ширхэг

6. "Стандарт агрикалчер групп" ХК-ийн халаасны хувьцааны тоо, ширхэг: 32,697 ширхэг

7. Хувьцаа худалдан авахаар санал болгох үнэ: 115 төгрөг

8. Хувьцааг худалдан авах төлбөрийг гүйцэтгэх өдөр: 2021.05.21

9. Худалдан авах санал гаргах болсон шалтгаан, зорилго: "Эм Ди Кэй Ай" ХХК нь компанийн хувьцааны хяналтын багцыг дангаараа худалдан авсан тул үүргээ хэрэгжүүлэх үндсэн дээр худалдан авах санал гаргаж байна.

10. Худалдан авах санал гаргагчийн худалдах саналыг хүлээн авах шуудангийн хаяг: Баянгол дүүрэг, 16-р хороо, Шинэ Монгол хаад группын байр, 2 давхар.

11. Худалдан авах санал гаргагчийн харилцагч үнэт цаасын компани "Стандарт инвестмент" ҮЦК ХХК. Утас: 99027432 Төрболд

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Сүхбаатарын талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747-2129



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN